

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар Тэргүүн Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгосон эрх үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2027 оны төсвийн төсөл, 2028-2029 оны төсөөллийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027-2029 оны төсвийн төслийг бэлтгэх удирдамж"-д нийцүүлэн боловсрууллаа.

Хууль эрхзүйн орчин

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2026-2030, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278, 108-р тогтоол, Сангийн сайдын 2018 оны 295, 2023 оны “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэр тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал” 137-р тушаал, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлал” 264-р тушаалаар баталсан журам, заавар, аргачлал зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагууд болох Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын хяналт, хэрэгжүүлэх газар, Оюуны өмчийн газар, Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Үндэсний Шинжлэх ухаан, технологийн сан, харьяа 6 хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар, харьяа 16 хүрээлэн нийт 29 байгууллагын төсөв нэгтгэсэн.

**Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтууд (дунд хугацаагаар),
бодлого чиглэл**

Нэг. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдааг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.

Хоёр. Дундаж давхаргыг дэмжиж, өрхийн бодит орлогыг хамгаалж, нийгмийн хамгааллын оновчтой тогтолцоогоор өрхийн орлогод үүсэх эрсдэлийг бууруулан, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлын түвшнийг 15 хувьд хүргэнэ.

Гурав. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгална.

Дөрөв. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 50 орны нэг болно.

Тав. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж Дэлхийн мэдлэгийн индексийг 52.4 оноонд хүргэнэ.

Дээрх бодлогын зорилтын хүрээнд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын “Гүйцэтгэх засаглалын удирдлага”, “70103”, Эдийн засаг, санхүү төсвийн судалгаа шинжилгээ”, “70206”, “Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх”, “70303”, “Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт”, “70410”, “Хөтөлбөр, төслийн удирдлага зохицуулалт”, “70419”, “Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт”, “70428”, “Шинжлэх ухаан, технологи”, “71805” кодтой дээрх хөтөлбөрийн 2027-2029 онд хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027-2029 оны төсвийн төслийг бэлтгэх удирдамж”-ийн Төсвийн саналын маягт хавсралтын “**ТМ-01а**” хэсэгт тодорхойлсон.

Бодлого чиглэл:

Нэг. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого төлөвлөх, боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хөтөлбөр арга хэмжээний зардлыг тооцон тусгав. Үүнд: хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; эдийн засаг, хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбар хоорондын уялдаа; хүний хөгжлийн нэгдсэн бодлого; хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих; макро эдийн засгийн бодлогын судалгаа, төлөвлөлт; шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, худалдааны бодлого; хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт; төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудалтай холбоотой хөтөлбөр, зориулалтын зардлыг хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хооронд байгуулсан 2026-2028 оны хамтын хэлэлцээрийн 3.1-д “Шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 2025 оны хүрсэн түвшнээс бууруулахгүй, 2026 онд 50-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 3.5 сая төгрөгт хүргэх асуудлыг 2027 оны төсвийн төсөлд тусгахад талууд хамтран ажиллана. Цалин хөлсийг шийдвэрлэх талаар талууд жил бүр нэмэлт хэлэлцээр байгуулна” гэж заасны дагуу 2027 оны төсвийн хязгаарт Үндэсний шинжлэх ухаан технологийн сангийн харьяа 6 хүрээлэн, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа 16 хүрээлэнгийн цалингийн санг нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгав.

Гурав. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.3.7.1” Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.”, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин” 10.1.1.1 “Судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаанд хувийн хэвшлийн санхүүжүүлсэн зардлын хэмжээ.” үр дүнгийн үзүүлэлтэд эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг жил бүр 10-25 % нэмэгдүүлэхээр заасан боловч 2027 оны төсвийн хязгаарын түвшинд зардлыг хянав.

Дөрөв. Хөрөнгийн зардлыг тооцохдоо Шинжлэх ухааны салбарын дунд хугацааны бодлогод үндэслэн “шилжих ажил” хэсэгт Шинжлэх ухааны нэгдсэн цогцолбор барилгын 2025 оны санхүүжилтийн үлдэгдэл 4.3 тэрбум төгрөг, Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр эхний 5 барилгын материалын үнийн өсөлт, хөдөлмөрийн хөлсний өөрчлөлтийг үндэслэн оффис, химийн лаборатори болон гадна талын тохижилтын ажлын төсөвт өртгийн 4.7 тэрбум төгрөг тус тус 2027 онд санхүүжүүлэх, “Шинээр” Одон орон судлах оргил дахь “Хүрэлтогоот” төвд судалгааны зориулалттай дурангийн байгууламжийн барилга угсралт нийт төсөв 3.2 тэрбум төгрөг, үүнээс 2027 онд 1.0 тэрбум, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн туршилтын амьтны байрны угсралтын ажил нийт төсөв 7.0 тэрбум, үүнээс 2027 онд 2.3 тэрбум тус тус санхүүжүүлэхээр, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах 2026 онд гэрээ байгуулсан 3.7 тэрбум төгрөг 2027 онд “үргэлжлүүлэн хэрэгжүүлэх” хэсэгт, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын багаж, тоног төхөөрөмж “Шинээр хэрэгжүүлэх” худалдан авах 19.8 тэрбум, Үндэсний Шинжлэх ухаан, технологийн сангийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн барилгын их засвар 0.6 тэрбум, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн GMP ус агаар модулийн их засвар 1.3 тэрбум төгрөг тус тус тусгав.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан байгуулах, журам батлах тухай” 405 дугаар тогтоолоор батлагдсан “Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих” журмын дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд улсын төсвөөс 1.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн 4 төслийн бүрэн шинжилгээ хийхээр төлөвлөлөө. Тус төслүүдийн шинжилгээ хийснээр Монгол Улсын 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 5.4.1 “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ”, 9.1.3 “Амжилттай зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны эзлэх хувийг нэмэгдүүлнэ” заалтад тус тус тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Урсгал зардлын тойм-зардлын дүн шинжилгээ:

Сангийн сайдын “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 2025 оны 112 дугаар тушаалын дагуу төсвийн төслийн 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2027 оны төсвийн төслийг шинэчлэгдсэн зарлагын ангиллын дагуу боловсрууллаа.

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2027 оны нийт төсөв 536.0 тэрбум төгрөг, үүний 31.7 хувь буюу 170.0 тэрбум төгрөг урсгал зардал, 68.3 хувь буюу 366.0 тэрбум төгрөг нь хөрөнгийн зардал эзэлж буй бөгөөд улсын төсвөөс 533.6 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,4 тэрбум төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин” 10.1.1 “Технологи дамжуулалт, патент, оюуны өмчийн ашиглалт, үнэлэмжийг нэмэгдүүлнэ.” гэсэн үр дүнг хангахын тулд Оюуны өмчийн газрын байгууллагын үйл ажиллагааны орлогыг 2027 онд суурь түвшнээс 10 % байхаар тооцов.

“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийн концессын гэрээний дагуу концессын эргэн төвлөрүүлэх орлого 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 39.8 тэрбум төгрөг, үүнээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөгөөр 11.5 тэрбум төгрөг тусгагдсан. 2027 онд 43.7 тэрбум төгрөг төвлөрүүлэх урьдчилсан тооцоо гарсны дагуу 100 % улсын төсөвт төвлөрүүлэхээр төсвийн саналд тусгав.

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
2026 ОНЫ ТӨСӨВ, 2027 ОНЫ ХЯЗГААР, 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН
САНАЛ**

/тэрбум.төг/

№	Зарлагын нэр төрөл	2026 оны батлагдсан төсөв	2027 оны төсвийн хязгаар	2027 оны байгууллагын санал	2027 оны төсвийн төсөл
1	Төсвийн орлогын дүн	13.9	13.9	46.1	46.1
1.1	Төсвийн байгууллагын өөрийн орлого	13.9	13.9	2.4	2.4
1.2	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	43.7	43.7
	Төсвийн зарлагын нийт дүн	213.9	147.6	718.7	536.0
2.1	Урсгал зардал	134.2	133.8	227.8	170.0
2.2	Хөрөнгийн зардал	79.7	13.8	490.9	366.0

Концессын төсөл

Засгийн газрын 2016 оны 226, 2017 оны 113 дугаар тогтоолоор эрх олгосон концессын төсөл, арга хэмжээний 2027 онд санхүүжих хөрөнгийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу тусган тооцлоо. Үүнд:

Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл-183.0 тэрбум төгрөг

Засгийн газрын 2016 оны 226 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу Хөрөнгө оруулалтын газар 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдөр "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай концессын гэрээг байгуулсан байна. Төслийн авто замыг 2024 оны 12 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгсөн.

Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл-121.4 тэрбум төгрөг

Засгийн газрын 2017 оны 113 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу Үндэсний хөгжлийн газар 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Шинжиан шинфа" ХХК-тай концессын гэрээг байгуулсан байна. Төслийн авто замын барилга угсралтын ажил 2024 оны 10 дугаар сарын байдлаар 72 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

ТЭЗҮ, зураг төсөв

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028), Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд ТЭЗҮ, зураг төсвийн ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, үргэлжлүүлэн хэрэгжиж буй ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил 2024 онд 4.1 тэрбум, 2025 оны 5.7 тэрбум төгрөг “үргэлжлүүлэн хэрэгжүүлэх”-т санхүүжүүлэхээр тусгав. Шинээр 13.8 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахаар төлөвлөлөө.

ТӨСВИЙН ХЯЗГААРААС ДАВСАН САНАЛЫН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил:

Мэдлэгт суурилсан эдийн засгийг цогцлоон байгуулахад чухал нөлөө үзүүлэх хүний нөөцийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь шинжлэх ухааны салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд билээ. ЭША-ны чадварлаг залуу үеийг бэлтгэх, дунд үеийг бэхжүүлэх, ахмад үеийг дэмжих замаар шинжлэх ухааны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах гол хүчин зүйл нь тэдний цалин хөлсний өндөр түвшин, нийгмийн хангамж, баталгааны асуудал байдаг. Сүүлийн үед Төр, засаг шинжлэх ухааны салбар хооронд харилцан ойлголцол, хамтын ажиллагаа сайжирч, төрөөс тодорхой ажлуудыг захиалж гүйцэтгүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг бүтээгдэхүүн, хэрэглээ болгох талаар анхаарч байна.

Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хооронд байгуулсан 2026-2028 оны хамтын хэлэлцээрийн 3.1-д “Шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 2025 оны хүрсэн түвшнээс бууруулахгүй, 2026 онд 50-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 3.5 сая төгрөгт хүргэх асуудлыг 2027 оны төсвийн төсөлд тусгахад талууд хамтран ажиллана. Цалин хөлсийг шийдвэрлэх талаар талууд жил бүр нэмэлт хэлэлцээр байгуулна” гэж заасны дагуу Үндэсний шинжлэх ухаан технологийн сангийн харьяа 6 хүрээлэн, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа 16 хүрээлэнгийн ажиллагсдын “ТҮШҮ-3” шатлалын цалинг 3,500,000.0 төгрөг хүргэхээр цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн төсвийн хязгаараас нэмэгдүүлэв.

Бусад урсгал зардлын саналыг 2027 оны төсвийн хязгаарын түвшинд боловсруулав.